



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТНОРОВ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 01 сарын 16 өдөр

Дугаар Б/03

Батноров сум

┌ Б.Чимэгсүрэнд ажил үүргийг хавсран
гүйцэтгүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1 дэх хэсэг, 109 дүгээр зүйлийн 109.6 дахь хэсэг, Сумын Засаг даргын Тамгын газрын даргын 2025 оны 01 сарын 28-ны өдрийн А/05 тоот тушаалаар батлагдсан "Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам"-ын 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Байгууллагын нийгмийн баталгааны хөтөлбөрийн 6 дугаар зүйлийн 6.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын мэргэжилтэн Б.Чимэгсүрэнд "E-mongolia" болон төрийн цахим үйлчилгээний "Хурдан цэг"-ийн ажлыг хавсран гүйцэтгүүлсүгэй.

2. Ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдлийг сар бүр үндсэн цалингийн 10 хувиар тооцон олгохыг Санхүү албаны нягтлан бодогч (Б.Энхжаргал)-д зөвшөөрсүгэй.



